

Улаанбурхан өвчний дэгдэлтийн талаарх түгээмэл асуулт, хариултууд

2016 оны 5 дугаар сарын 11

ДЭГДЭЛТИЙН ТУХАЙ БАРИМТУУД:

1. Дэгдэлт хэзээ, хаана, яагаад гарсан бэ?

- Одоогоор байгаа мэдээллээр дэгдэлт 2015 оны 3 дугаар сараас өмнө эхэлсэн байх магадлалтай.
- Дэгдэлт чухам хаана эхэлсэн нь тодорхойгүй ч хамгийн анхны албан ёсоор мэдээлэгдсэн тохиолдол Улаанбаатар хотын Чингэлтэй дүүрэгт бүртгэгджээ.
- Лабораторийн шинжилгээгээр энэхүү анхны тохиолдлоос илрүүлсэн улаанбурханы вирусийн генотип нь БНХАУ-д тархаж буй вирусийн генотиптэй төстэй байсан.

Дэгдэлт дараах нөхцөл байдлын улмаас гарсан:

- улаанбурхан өвчний үүсгэгч вирус гадаад орноос орж ирсэн
- улаанбурхан өвчний эсрэг дархлаагүй (өртөмтгий) хүмүүс нэг дор олноор төвлөрсөн байсан
- улаанбурхан өвчний вирус өртөмтгий хүнд дамжин халдварлах зам нь нээлттэй байсан (улаанбурхан өвчин нь амьсгалын замаар тархдаг)

2. Хэн өртөх/өвдөх эрсдэлтэй вэ?

Улаанбурхан өвчний эсрэг дархлаагүй хүн бүр өвдөх эрсдэлтэй. Үүнд:

- Улаанбурхан өвчний эсрэг вакцины 2 тунг бүрэн хийлгээгүй хүмүүс эсвэл
- Улаанбурхан өвчнөөр өвдөж байгаагүй хүмүүс

3. Хамгийн сүүлийн үеийн мэдээгээр өвчлөл ямар байна вэ? Энэхүү дэгдэлтийн улмаас хэдэн хүн тэр дундаа хэдэн хүүхэд эндээд байна вэ?

Эрүүл мэнд, спортын яамны мэдээлснээр энэ оны эхний дөрвөн сарын байдлаар 105 хүн эндсэн байна. Эдгээр тохиолдлуудын 59 нь лабораторийн, 46 нь эмнэлзүйн шинжилгээгээр оношлогдсан байна. Эндэсэн хүмүүсийн 90% нь 0-8 сартай нялхас юм. 2016 онд бүртгэгдсэн нийт сэжигтэй болон батлагдсан тохиолдлын тоо нь 23,888 хүрээд байна.

өвчнөөр хүндэрдэг нь улаанбурхан өвчинтэй холбоотой шалтгаанаар нас барж буй хүүхдийн тоог нэмдэг.

6. Товлолын улаанбурхан-гахайн хавдар-улаануудын (УГУ) эсрэг хавсарсан вакцин хийлгэсэн хүмүүс яагаад өвдөөд байна вэ?

- Нас:
 - 8-9 сартайдаа улаанбурханы эсрэг вакцин хийлгэсэн нялхсын дунджаар 89.6%-д нь улаанбурхан өвчний эсрэг дархлаа тогтдог.
 - 11-12 сартайдаа вакцин хийлгэсэн нялхсын дунджаар 99%-д нь дархлаа тогтдог.
 - Эхний тунгаа хийлгэсний дараа дархлаа тогтоогүй хүүхдүүдэд хийсэн судалгаанаас үзэхэд хоёр дахь тунг хийсний дараа бараг бүх хүүхдэд дархлаа тогтдог болох нь харагдсан.
 - Тиймээс, улаанбурхан, гахай хавдар, улаануудын эсрэг товлолын гуравт вакциныг 9 сартайдаа хийлгэсэн хүүхдүүдийн 10 орчим хувьд нь дархлаа тогтоогүйн улмаас тус өвчнөөр өвчилж байна. Монголд улаанбурхан өвчний эсрэг товлолын вакциныг 9 сар, 2 настайд нь хийдэг.
- Дархлаажуулалтын цоорхой:
 - Монгол Улс дахь дархлаажуулалтын хамралтын хувь маш өндөр буюу 96% хэмээн тайлагнадаг ч улаанбурхан өвчний энэхүү дэгдэлтээс харахад зарим насны хүмүүсийн дунд дархлаажуулалтаас хоцорсон байдал нэлээд байгаа нь харагдаж байна.

7. Энэ оны 5-дугаар сард яагаад 18-30 насны хүмүүст улаанбурхан-улаануудыг эсрэг вакциныг хийх гэж байна вэ?

Эпидемиологийн судалгаанаас харахад 18-30 насны залуучууд мөн 9 сар хүрээгүй буюу улаанбурхан өвчний эсрэг вакцины эхний тунгаа авах болоогүй нялх хүүхдүүд хамгийн их өвчилж байна.

Үүнээс дүгнэхэд дараах насныхны дунд дархлаагүй хүн олон байна:

- 18-30 насныхан нь нийгэм, эдийн засгийн шилжилт, эрүүл мэндийн салбарт хүндрэл бэрхшээл их тулгарч байсан үед буюу 1986-1998 оны хооронд төрсөн хүмүүс учир улаанбурхны дархлаажуулалтад хамрагдаагүй хүн олон байх магадлалтай.
- Шинэ төрсөн хүүхэд 6-9 сар хүртлээ эхээсээ авсан дархлаатай байдаг. Харин эх нь өөрөө дархлаагүй тохиолдолд хүүхэд дархлаагүй төрөх бөгөөд улаанбурхан өвчний эсрэг вакциныхаа анхны тунг 9 сартайдаа авах хүртлээ улаанбурхны вирүсээр өвчлөх эрсдэлтэй, өртөмтгий байна.

Иймээс Монгол Улсын Засгийн газар 18-30 насны хүмүүсийг 2016 оны 5 дугаар сарын 12-25 өдрүүдэд нэмэлт дархлаажуулалтад хамруулах шийвэр гаргасан.

8. Энэхүү дэгдэлт цаашид хэр удаан үргэлжлэх бол?

18-30 насны залуу хүмүүсийг нэмэлт дархлаажуулалтад хамруулах нь тархалтыг хязгаарлахад тусална. Улаанбурхан өвчнөөр өмнө нь өвдөж байгаагүй эсвэл вакцин

хийлгэж байгаагүй буюу өөрөөр хэлбэл тус өвчний эсрэг дархлаагүй хүмүүс улаанбурхан өвчний эсрэг дархлаажуулалтад хамрагдах нь нэн чухал. Улаанбурхан өвчний эсрэг дархлаагүй хүмүүс энэ дэгдэлтийн хүрээнд халдвар авах эрсдэл нь өндөр байна.

9. Энэхүү дэгдэлтийг таслан зогсоох талаар ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай вэ?

- Товлолын дархлаажуулалтын хамралтыг сайжруулж, товллолын вакцинаас хүүхдүүдийг хоцроохгүй байх;
- Олон нийтэд ухуулга нөлөөлөл, мэдээлэл сурталчилгаа, эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагаа явуулах;
- Тандалт, үүн дотроо тохиолдлын илрүүлэлт, тархварзүйн судалгааг эрчимжүүлэх;
- улаанбурханы сэжигтэй тохиолдлуудыг тусгаарлах;
- халдвар авсан өвчтөнүүдийн оношлогоо, эмчилгээг сайжруулах;
- эмнэлгээс шалтгаалах халдвар хэлбэрээр тархахаас сэргийлэх;
- 18-30 насны хүмүүст улаанбурхан-улаануудын нэмэлт дархлаажуулалтыг хийх

УЛААНБУРХАН-УЛААНУУДЫН НЭМЭЛТ ДАРХЛААЖУУЛАЛТЫН ТУХАЙ:

1. 18-30 настай хүмүүст нэмэлт дархлаажуулалт хийх хугацаа хэзэ вэ?

2016 оны 5 дугаар сарын 12-25-ны өдрүүдэд хийнэ.

2. Улаанбурханы нэмэлт дархлаажуулалтын аяны хүрээнд хэдэн тун вакцин хийх вэ?

Вакцин хийлгэх шаардлага хангасан хүнд нэг тун хийнэ.

3. Дархлаажуулалтыг хаана хийх вэ?

Өрхийн эрүүл мэндийн төв, эмнэлэг, Дүүргийн эрүүл мэндийн төв, их дээд сургууль, албан байгууллагуудаар хийнэ.

4. Улаанбурханы эсрэг вакцины нэмэлт тунг хийлгэх нь аюулгүй юу?

- Өмнө та вакцин хийлгэсэн, хийлгээгүй эсэхээс үл хамааран нэмэлт тунг хийлгэхэд аюулгүй. Гэхдээ улаанбурхан өвчний вакциныг нэг сар ба түүнээс бага хугацааны өмнө хийлгэсэн бол нэмэлт дархлаажуулалтын тун авах шаардлагагүй.

5. Яагаад дан улаанбурхан биш улаанбурхан-улаануудын хавсарсан вакцин хийх гэж байгаа юм бэ?

18-30 насны хүмүүст улаануудын эсрэг вакцин хийснээр тухайн хүн улаануудаар өвчлөх, тус өвчин дэгдэх, мөн улаануудаас үүдэлтэй төрөлхийн гажиг ирээдүйн ураг ба нярайд үүсэхээс сэргийлнэ.

Монгол Улсад улаанбурхан-улаануудын хавсарсан вакцинаар нэмэлт дархлаажуулалтыг 2012 онд хийж 3-14 насны хүүхдүүдийг хамруулсан. Тиймээс 1998 оноос хойш төрсөн хүүхдүүд л улаануудаас сэргийлэх вакцин хийлгэсэн гэсэн үг.

6. 18-30 настнуудад 5 дугаар сард хийх улаанбурхан-улаануудын нэмэлт дархлаажуулалтад хамрагдаж болохгүй сөрөг заалт бий юу?

18-30 насныханд хийгдэх вакцин нь улаанбурхан-улаанууд өвчний эсрэг хавсарсан вакцин юм. Хэдийгээр практик нотолгоогүй ч онолын үүднээс жирэмсэн эмэгтэйн урагт төрөлхийн гажиг үүсгэж болзошгүй гэж үздэг тул улаануудын вакциныг жирэмсэн эмэгтэйд хийдэггүй. Жирэмслэхээр төлөвлөж байгаа бол жирэмслэлтийг улаануудын вакцин хийлгэсний дараа 1 сарын хугацаагаар хойшлуулах хэрэгтэй. Улаануудын вакциныг хийхийн өмнө тухайн эмэгтэйгээс жирэмсэн эсэхийг нь асуух ёстой. Мөн аливаа өвчний хурц үед байгаа эсвэл өмнө нь ямар нэг вакцинд харшил өгч байсан бол вакцин хийхгүй.

УЛААНБУРХАНЫ ВИРУСИЙН ТУХАЙ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ:

1. Улаанбурхан гэж юу вэ?

- Улаанбурхан бол вирусээр сэдээгддэг маш халдвартай хүнд өвчин юм. Улаанбурханы эсрэг дархлаажуулалт нэвтрэхээс өмнө 1980 онд жил бүр 2.6 сая хүн уг өвчний улмаас нас бардаг байв. Үүнээс хойш уг өвчний эсрэг аюулгүй, үр дүнтэй вакцины хүртээмж сайжирсан боловч улаанбурхан дэлхийн хэмжээнд бага насны хүүхдийн эндэгдлийн тэргүүлэх шалтгааны нэг хэвээр байна. 2012 онд 122,000 орчим хүн улаанбурханы улмаас нас барсны ихэнхийг тав хүртэлх насны хүүхдүүд эзэлж байв.

2. Ямар шинж тэмдгээр илэрдэг вэ?

- Улаанбурхан өвчин голдуу өндөр халуурах шинж тэмдгээр эхэлж илэрдэг. Халууралт голдуу халдвар авснаас хойш 10-12 хоногийн дараа илэрч, 4-7 хоног үргэлжилдэг байна. Өвчний эхэн үед нусгайрах, ханиалгах, нүд улайх, нулимс гоожих, хацрын дотор талд жижиг цагаан толбо гарах шинж тэмдэг илэрч болно. Хэд хоногийн дараагаас голдуу нүүр, хүзүүгээр тууралт гарч, гурав хоногийн дотор бүх биеэр тархаж, хамгийн сүүлд сарвуу, тавхайгаар туурдаг. Тууралт 5-6 хоногийн дараа бүдгэрч алга болдог.

3. Өвчин хүндрэх ямар эрсдэл байдаг вэ? Хүндрэх эрсдэл хэр их өндөр вэ?

- Улаанбурханы улмаас эндсэн тохиолдлуудын ихэнх нь хүндрэлээс болж нас бардаг. Хүндрэл голдуу тав хүртэлх насны хүүхэд, 20-иос дээш насны насанд хүрэгчдэд илэрдэг байна. Өвчний хүндрэлээс хараагүй болох, энцефалит (буюу тархи хавагнахад хүргэдэг халдвар), хүнд хэлбэрийн суулгалт ба усгүйжил, чихний халдвар, уушгины хатгаа зэрэг амьсгалын замын хүнд халдвар авах нь нэлээд ноцтой юм. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ муу, хүн амын дунд хоол тэжээлийн дутал түгээмэл нөхцөлд улаанбурханаар өвдсөн тохиолдлуудын 10 хүртэлх хувь нь нас бардаг. Жирэмсэн эмэгтэйчүүд улаанбурханаар өвдсөн тохиолдолд зулбах, дутуу төрөх болон бусад ноцтой хүндрэл гарах эрсдэл өндөр байдаг. Хоол тэжээлийн доройтолтой, нэн ялангуяа А аминдэмийн дуталтай, ХДХВ/ДОХ буюу бусад өвчний улмаас дархлалын тогтолцоо нь суларсан бага насны хүүхдүүдэд өвчин хүнд хэлбэрээр явагдах хандлагатай байдаг.

4. Улаанбурханы вируст хэн хамгийн өртөмтгий вэ?

- Вакцинжуулалтад хамрагдаагүй бага насны хүүхдүүдэд улаанбурханаар өвдөх, хүндрэх, нас барах эрсдэл хамгийн өндөр байдаг. Вакцинжуулалтад хамрагдаагүй жирэмсэн эмэгтэйчүүд мөн өндөр эрсдэлтэй бүлэгт багтна.

Улаанбурханы эсрэг дархлаагүй хэн болов ч уг өвчнөөр өвдөх магадлалтай. Энэ нь голдуу улаанбурханы вакцины хоёр тунд хамрагдаагүй хүмүүс байдаг.

5. Улаанбурханы эсрэг анхны вакциныг дэлхийд болон Монгол Улсад хэзээ анх нэвтрүүлсэн бэ?

- Улаанбурханы эсрэг амьд, сулруулсан вакциныг голдуу Эдмонстон төрлийн улаанбурханы вирусээс гарган авдаг ба энэхүү төрлийн вирусийг анх 1954 онд Эндерс, Пиблс нар ялган авсан байна. Эдмонстон төрлийн вирусээс Шварц, Эдмонстон-Загреб, АИК-С, Моратен зэрэг олон төрлийн вирус гарган авч, 1960-аад оноос хойш вакцины үйлдвэрлэлд ашиглаж иржээ.
- Монгол Улсад улаанбурханы эсрэг нэг удаагийн дархлаажуулалтыг үндэсний товлонд 1973 оноос нэвтрүүлсэн байна.

6. Улаанбурханы эсрэг дархлаажуулалтад хэн хамрагддаг вэ?

- Монгол Улсын Үндэсний дархлаажуулалтын товлон ёсоор улаанбурханы эсрэг вакциныг 9 сартай болон 2 настай хүүхдүүдэд хийдэг. 206 оны 5 сард, 18-30 насны бүх хүнд улаанбурхан өвчний вакцины нэмэлт тунг хийнэ.

7. Энэтхэгийн “Serum Institute” хүрээлэнгээс импортолж, Монгол Улсад хэрэглэж байгаа улаанбурхан, улаанууд, гахай хавдрын эсрэг гуравт вакцин хэр үр дүнтэй вэ?

- Монгол Улсад хүүхдийн дархлаажуулалтад ашиглаж байгаа бүх вакцинууд ДЭМБ-аас чанар, үр дүн нь урьдчилан баталгаажсан, НҮБ-ын ханган нийлүүлэлтийн тогтолцооны дагуу олон улсын тендэрээр нийлүүлэгддэг.

8. Вакцины зардлыг улсын төсвөөс гаргадаг уу?

Үндэсний товллын дагуу бага насны хүүхдүүдэд хэрэглэж буй улаанбурханы эсрэг вакцины зардлыг улсын төсвөөс гаргадаг. Энэ удаагийн нэмэлт дархлаажуулалтын хүрээнд 18-30 насныханд хийх улаанбурхан-улаанууд өвчний эсрэг вакцины төсвийг мөн улсын төсвөөс гаргаж байна.

9. Өмнө нь улаанбурханаар өвдсөн хүн дахиж халдвар авах эрсдэлтэй юу?

Үгүй, хэрэв хүн улаанбурханы байгалийн вирусийн халдвар авч өвчилсөн бол түүнд насан туршийн дархлаа тогтдог учраас дахин улаанбурханаар өвдөх эрсдэлгүй юм.

10. Өмнө нь улаанбурханаар өвдөж байгаагүй 40-өөс дээш насны хүмүүс өнөөгийн дэгдэлтийн үед халдвар авах эрсдэл хэр их вэ?

Хэрэв тухайн хүн өмнө нь улаанбурханы эсрэг хоёр тунгийн вакцинжуулалтад хамрагдаагүй бол халдвар авах эрсдэл өндөр.

11. Улаанбурханы эсрэг вакциныг аль ч насны хүнд хийж болох уу?

6 сараас дээш насны (жирэмсэн эмэгтэйчүүдээс бусад) хүмүүс вакцин хийлгэж болно.

12. Насанд хүрсэн хүн төлбөр төлөөд сайн дураар улаанбурханы эсрэг дархлаажуулалтад хамрагдаж, өөрийгөө халдвараас хамгаалж болох уу?

Тийм, сайн дурын дархлаажуулалтыг ХӨСҮТ-ийн амбулаторийн дархлаажуулалтын кабинетаар хийж байгаа.

ТАНАЙ ГЭР БҮЛИЙН ГИШҮҮНД УЛААНБУРХАН ӨВЧНИЙ СЭЖИГ ИЛЭРВЭЛ ЯАХ ВЭ?

- Улаанбурхы халдвар авснаас 2 дахь долоо хоногт өвчин илэрнэ. Улаанбурхан өвчний анхны шинж тэмдэг нь халуурах, нусгайрах, ханиалгах, нүд улайх буюу нулимс гоожих, гэрэлд нүд гялбах зэрэг юм. Эдгээр шинж тэмдэг илэрснээс 1-2 хоногийн дараа тууралт гарч эхэлнэ.
- Халдварт өвчин судлалын үндэсний төвийн түргэн тусламжийн 100 дугаар утас эсвэл харьяа өрх, сумын эмнэлэгт яаралтай хандаарай.
- Халдвар авсан байж болзошгүй хүнд тууралт илэрснээс хойшхи 5 хоногийн хугацаанд гэр бүлийн гишүүд нь орох, гарах хөдөлгөөнөө хязгаарлах хэрэгтэй. Халдвар дамжих эрсдэл нь тууралт гарснаас хойш хоёр дахь хоногоос хойш ихээхэн буурдаг. (Улаанбурхан өвчний хүндрэл өгөөгүй хүн эмнэлгээс шалтгаалах халдвар тархаахаас сэргийлэх үүднээс эмнэлэгт хэвтэхээс зайлсхийх хэрэгтэй. Эмнэлгийн нөхцөлд улаанбурханы халдварын сэжигтэй өвчтөнүүдийг шинж тэмдэг илэрснээс эхлэн тууралт гарснаас хойшхи 5 дахь өдөр хүртэл тусгаарлах хэрэгтэй).
- Хавьтал гэж улаанбурханаар өвдсөн хүнтэй халдвартай үед нь (буюу тууралт гарахаас өмнөх 5 хоногоос тууралт гарснаас хойшхи 5 хоногт) нэг өрх гэрт, хөрш зэргэлдээ амьдарч байсан буюу хамт ажиллаж байсан хүнийг тус тус хэлнэ.
- Улаанбурхан өвчний эсрэг вакцинжуулалтад өмнө нь хамрагдаж байсныг нотлох баримт байхгүй, хавьтлуудыг нэн даруй вакцинжуулах хэрэгтэй. Мөн хавьтлуудад өвчний нууц үеийн шинж тэмдгийн тухай тайлбарлан өгч, хавьтал болсноос хойш бүтэн 2 долоо хоног өнгөртөл бусад хүнээс өөрийгөө аль болох тусгаарлах талаар зааварчилгаа өгнө.
- Өвчтөнд тууралт гарч эхэлснээс хойш 14-өөс цөөн хоног өнгөрсөн бол түүний бүх хавьтлуудад дархлаажуулалтад хамрагдсан эсэхээс нь үл хамаарч тусгаарлах зааварчилгаа өгнө.
- Тохиолдолтой хавьтал болсны дараах хоёр дахь долоо хоногт улаанбурхан байж болзошгүй шинж тэмдэг (халуурах, нусгайрах, ханиалгах, гэрэлд гялбах) илэрвэл тэр даруйд нь тухайн хавьталд гэртээ байх зааварчилгаа өгнө. Тухайн хавьталд сургууль, цэцэрлэг, ажил, сүм хийд, клуб, уулзалт, үдэшлэг зэрэг хүн ам олноор цугларсан газраар явахгүй байхыг зааварлана. Улаанбурханаар өвдсөн тохиолдолд 1-2 хоногийн дараа өвчний шинж тэмдэг илэрнэ эсвэл тууралт гарна. Тууралт гарч эхлэнгүүт эцэг эхчүүд, гэр бүлийн бусад гишүүд эрүүл мэндийн байгууллагад мэдэгдэнэ.